

Г.Лхагвасүрэн

Шашин судлалын тэнхмийн
эрхлэгч доктор, профессор

**Сэтгэлийн төдийтний гүн ухаан
дахь “хоёр үгүйн” үзэл**

Түлхүүр ойлголтууд: Хоёрын үзэл, хоёр үгүйн үзэл, онохуй, оногдохуй хоёр, ном, номын чанар, номын бэлгэ чанар, номын чанарын бэлгэ чанар, сансар, нирван зэрэг

Үндсэн агуулга: Буддын гүн ухааны нэгэн үндсэн чиглэл болсон сэтгэлийн төдийтөн (Chitta-matra) буюу тийн ухахуйн төдийхнөө өгүүлэгчийн (Vijnanavada) сургаал дахь хоёр үгүйн аргазүйг тусгайлан авч үзжээ. Хоёр үгүйн үзэл нь төв үзлийн аргазүйг сэтгэлийн төдийтнөө буулгасан нь бөгөөд танин барихуй дахь онохуй, оногдохуй хоёрын гүн нэгдэл, шүтэн барилдлагын тухай сургаал болно гэж үзжээ

Буддын гүн ухааны сэтгэлийн төдийтний үзэл сургаалын үндсийг тавьсан “Майдарын хутагтын” хэмээх таван номны нэгэн – “Ном хийгээд номын чанарыг сайтар ялгагч” /Dharma-dharmata-vibhanga/ шасдирт: “Барихуй хийгээд баримтлахуй ба өгүүлэхүй хийгээд өгүүлэгдэхүй ялгал үгүй түүнчлэнхүү...”¹ гэж нягтад хураангуйлан тодорхойлсон буй. Үүнийг дэлгэрүүлэн тайлбарлаж тус гүн ухааны “тэргэн журам нээгчдийн” нэгэн, гарамгай гүн ухаантан Васубанду бээр өгүүлэхдээ: “Энэ нь баригдахуун болой. Энэ нь баригч болой хэмээх буюу, энэ нь өгүүлэгдэхүүн болой, энэ нь өгүүлэн үйлдэгч болой хэмээх хоёр буюу. Өгүүлэгдэхүүн хийгээд өгүүлэн үйлдэгч буй хэмээвээс ялгал буй болох бөгөөд тэр үгүйн тул хэмээвээс ялгал үгүй түүнчлэн чанар болой”² хэмээн баригдахуун хийгээд баригч, өгүүлэгдэхүүн хийгээд өгүүлэн үйлдэгч буюу танин барихуй дахь оногдохуй, онохуй /объект, субъект/ хоёрыг буй, өөрөөр хэлэхүл, тус тусдаа биеэ дааж, эсэргэцэлдэн оршдог, үнэнхээр бүтчихсэн зүйлс хэмээвээс “хоёрын үзэл” /dvaya-vada/ болж, харин тэдгээр тус бүрийг өөр хоорондоо шүтэн барилдсан, үнэнхээр бүтээгүй хэмээвээс “хоёр үгүйн үзэл” /advaya-vada/ болно гэсэн буй; ингээд тэрхүү “хоёр үгүйн” чанар буюу онохуй, оногдохуй хоёрын

¹ Майтреянатха, Ном хийгээд номын чанарыг сайтар ялгагч, -Монгол Данжуур, 132 дугаар боть, 65 дахь хуудас, доорд

² Васубанду, Ном ба номын чанарыг маш ялгагч тайлбар, -Монгол Данжуур, 133 дугаар боть, 40 дэх хуудас, дээд

дотоод адилсал, гүн нэгдлийг “түүнчлэн чанарын” /*lathata*/ категори лугаа адилтгаж тавьсан болно.

Энэ бол хэрэг дээрээ сэтгэлийн төдийтний гүн ухаанд сэтгэлгээний үндсэн аргагүйгээ тодорхойлсон хэрэг мөн гэж үзэж байна: монгол Данжуур дахь “Хутагт Ланка дор ажирсны тайлбар” /*Lanka-avatara-vritti*’/ хэмээх шасдирт нотлон өгүүлэхдээ: “Хоёр үгүйн үнэмлэхүй үнэнийг онон үйлдэхүй энэ нь их хөлгөний йога хэмээх болой”³ гэж онцолж тэмдэглэсэн буй. Тийнхүү угтаа эл бүхий “хоёр үгүйн” үзлийг бурхантны дээдийн зорилго болсон үнэмлэхүй үнэн лүгээ адилтган тавиад, чухамхүү эл “хоёр үгүйн” үнэнийг онон бариснаар л сэтгэлийн төдийтний гүн ухаан гарсан юм гэж, үүгээр тус гүн ухаан дахь “хоёр үгүйн үзлийн” тулгуур учир холбогдлыг товойлгож тавьсан утга санаа энд тодорхой гарч байна.

Үүнд дурдахуйяа, буддын сэтгэлгээний уламжлалаар бол: Шакъямуни бурханыг нирван хутагт ажирснаас даруй 600 буюу 900 жилийн дараа сэтгэлийн төдийтний гүн ухааныг үүссэн гэдэг.⁴ Харин өнөөгийн буддын судлалч олонхи эрдэмтэн тус чиглэлийн үүслийг даруй аргын тооллын IY буюу Y зууны үед холбогдуулан дүгнэж буй.⁵ Ямар ч бол, буддын гүн ухааны өмнөх бүх түүхэн хөгжлийн нь үр дүн, сүүлчийн - дөтгөөр үндсэн чиглэл нь болж сэтгэлийн төдийтний гүн ухаан үүссэн нь эргэлзээнгүй буюу.

Эсхүл, монголын их бичгийн хүн, билгүүн номч, гүн ухаантан Заваа Дамдин гавж бээр “Тогтсон тааллын тийн агуулгыг хураангуйлан тэмдэглэсэн

³ Жнянашрибадра, Хутагт Ланка дор ажирсны тайлбар, -Монгол Данжуур, 130 дугаар боть, 23 дахь хуудас, дээд

⁴ Туган гэгээн Лувсанчойжням, Тогтсон таалал бүхний уг хийгээд таалах ёсныг номлосон сайн номлол Болорын толь оршвой, УТНС, гар бичмэлийн хөмрөг, Тэргүүн дээтэр, 48 дахь тал. Түүнчлэн: History of Buddhism (Chos-hbyung) by Bu-ston. II Part. The History of Buddhism in India and Tibet. Translated from Tibetan by Dr. E. Obermiller. Reprint Ed. Delhi: Sri Satguru Publications, 1986. The Blue Annals. Translated and Interpreted by G. Roerich. Reprint Ed. Delhi: Motilal Banarsidass Publishers, 1976. Taranatha. Taranatha's History of Buddhism in India. Translated by Lama Chimpa and Alaka Chattopadhyaya, Simla: Indian Institute of Advanced Study, 1970 болон бусад

⁵ Raxyla Valpola, Asanga, -in: Encyclopaedia of Buddhism. Vol. II. Ed. by G.P. Malalasekera. Ceylon: Government Press. 1966. p.136. Takakusu J., A Study of Paramartha's Life of Vasubandhu and the Date of Vasubandhu, -in: Journal of the Royal Asiatic Society, 1905. pp. 33-53. Noel Peri, A propos de la date de Vasubandhu, -in: Bulletin de l'Ecole Française d'Extreme Orient, XI, pp. 339-390. Indian Studies in Honour of Charles Rockwell Lanman, Cambridge: Mass., 1929. pp. 79-88, 89-92, Wayman A., Analysis of the Sravakabhumi Manuscript. Berkley: University of California Press, 1961, pp. 19ff. The Encyclopedia of Eastern Philosophy and Religion. Boston: Shambhala, 1989. pp.19, 401. Dictionnaire de la sagesse orientale, Paris: Editions Robert Laffont, 1989. pp. 28, 639. **Жич:** Сэтгэлийн төдийтний гүн ухааныг Y зууны үед үүссэн гэх санал дүгнэлт мөн буй нь: Levi Sylvain, Mahayanasutralamkara, Paris, 1911, Introduction. pp. 1-7. Mahayana-sutralamkara. Ed. by S. Bagchi. Dharbhanga: Mithila Institute, 1970, Introduction, p.11. **Өөр бусад саналд дүгнэлтийн тоймыг:** Winternitz M., A History of Indian Literature, Vol. II. 2nd Edition, New-Delhi: -Oriental Books Reprint Corp., 1972, pp. 355-356, n.6. Nariman J.K., Literary History of Sanskrit Buddhism. Reprint Edition. Delhi: Motilal Banarsidass Publ., 1972. pp. 96-97 зэргээс тодруулан үзнэ үү.

гол номын далайд зорчих эрхийн бичиг” хэмээх думта бүтээлдээ онцолж тэмдэглэсэнчлэн: “Ба бүрний багш тэнцэшгүй Шагжийн хаан тэр ямагт бээр анханд бодийн дээдэд тааллыг үүсгэн, завсар дор тоолшгүй гурван галавт буяныг хурааж, эцэст Очирт суурины орноо илтэд туулсан бурхан болсон бөгөөд Варанасын нутагт таван аймаг шавьд анхдугаар зарлиг - дөрвөн үнэний номын хүрднийг, Тасын цогц уулнаа дундад зарлиг - бэлгэ чанар үгүйн номын хүрднийг, эцэст Ямбатны тэргүүтэн газраа сүүлийн зарлиг - машид ялгалсан номын хүрдэн тэргүүтнийг агуу ихэд эргүүлснээр амьтан нугуудын амгалан жаргаланг хөгжөөхүй дор их эрдэнэ шашиныг өнө удаанд оршуулан зохиосон болой” гэж бурханы шашин гарсан дэлгэрсэн бүх ёсныг номын гурван хүрднээр зангидан хурааж илэрхийлээд улмаар “Түүний сүүлд тайлбарлагч нугууд бээр гурван хүрдний тааллыг тус тусад нь тайлбарласнаар тогтсон тааллыг өгүүлэгч дөрөв гарсан болой. Тэр ямагтаас судартан, өвөрмөц өгүүлэгч хоёр нь анхдугаар хүрднийг, бэлгэ чанар үгүйд өгүүлэгч нь думдад хүрднийг, егүзэрийн явдалтан нугууд нь эцсийн номын хүрднийг даган мөрдөж, суурь, мөр, үр гуравны тийн агуулгыг тангаргаласан буй”⁶ гэж буддын гүн ухааны үндсэн дөрвөн чиглэл тус бүрийг номын гурван хүрдэн лүгээ холбон хураангуйлж тодорхойлсон буй. Тийнхүү буддын сэтгэлгээний уламжлалаар бол **анхдугаар – дөрвөн үнэний номын хүрднийг** даган баримталснаар **тайлбартны буюу өвөрмөц өгүүлэгчдийн** хийгээд **судартны буюу үлгэр өгүүлэгчдийн** хэмээх хоёр чиглэл гарч, **думдад – бэлгэ чанар үгүйн номын хүрднийг** даган баримталснаар **бэлгэ чанаргүйд өгүүлэгч буюу төв үзлийн**, сүүлчийн **гутгаар – маш сайтар ялгалсан номын хүрднийг** даган баримталснаар **сэтгэлийн төдийтний буюу тийн ухахуйн төдийхнөө өгүүлэгчийн** тогтсон таалал тус тус гарсан гэж үздэг болно.

Ямар ч бол, буддын сэтгэлгээний уламжлалын үүднээс ч, өнөөгийн буддын судлалч эрдэмтдийн судалгаа дүгнэлтээр ч, сэтгэлийн төдийтний гүн ухаан нь төв үзэл – хоосон чанарын гүн ухааныхаа дараа үүссэн буюу тэдгээрийн аль алин нь Шакъямуни бурханы дундад зарлиг – билиг барамидын сургаалаас урган гарч буй хийгээд энэ утгаараа сэтгэлийн төдийтөн нь өмнөх “бэлгэ чанар үгүйн хүрдэн”, түүний гүн ухааны үндсэн агуулга, үр дүн болсон хоосон чанарын сургаалыг чухамхүү сэтгэлгээний аргазүй болох утгаар нь нэгэн адил дэмжин баримталдаг ажгуу хэмээн дүгнэж бүрнээ болох байна; эл бүхий

⁶ Заваа Дамдин гавьж, Тогтсон тааллын тийн агуулгыг хураангуйлан тэмдэглэсэн гол номын далайд зорчих эрхийн бичиг хэмээх оршвой, 23 дахь хуудас,

байдал нь ялангуяа тус, гутгаар номын хүрдэн дэх “хоёр үгүйн үзлээр” тод илэрч байгаа юм гэж үзнэ.

Өмнөх, думдад номын хүрднээ аливаа бүх эсрэг тэсрэгийн түгээмэл шүтэн барилдлагыг ертөнцийн язгуур үндэс, уг зарчим болгон баримталж, бүгдийг энэхүү түгээмэл шүтэн барилдлагын үүднээс, түүнд тулган авч үзсэн бөлгөө. Ингэж үзэх явдал энэхүү думдад номын хүрднээ сэтгэлгээний нь үндэс, үндсэн аргагүй нь болж асан ажгуу.

Чингэхүйеэ, сэтгэлийн төдийтний гүн ухааныг үндэслэгч дундад эртний энэтхэгийн гарамгай гүн ухаантны нэг Асанга бээр “Их хөлгөний хураангуй” (Mahayanasamgraha) хэмээх их хөлгөн бүтээлдээ: “Хэр мэт мөнх ба мөнх бус хийгээд хоёр үгүй, түүнчлэнхүү жаргалан ба зовлон хийгээд хоёр үгүй ба буян ба буян бус хийгээд хоёр үгүй ба хоосон ба хоосон бус хийгээд хоёр үгүй ба би ба би үгүй хийгээд хоёр үгүй ба амарлисан ба эс амарлисан хийгээд хоёр үгүй ба мөн чанарт ба мөн чанар үгүй хийгээд хоёр үгүй ба төрсөн ба эс төрсөн хийгээд хоёр үгүй ба түрдсэн ба эс түрдсэн хийгээд хоёр үгүй ба угаас амарлисан ба угаас эс амарлисан хийгээд хоёр үгүй ба төрөлх гаслангаас нөгцсөн ба төрөлх гаслангаас эс нөгцсөн хийгээд хоёр үгүй ба орчлон ба нирван хийгээд хоёр үгүй болой...”⁷ гэж энэхүү хоёр үгүйн үзлийнхээ үүднээс тодорхойлсон буй. Эндээс үзэхүл, дээрх ишлэлд дурдагдан буй мөнх хийгээд мөнх бус, жаргалан хийгээд зовлон, төрөх хийгээд эс төрөх, түрдэх хийгээд эс түрдэх тэргүүтэн аливаа бүх эсрэг тэсрэг тал шинжүүдийн аль нэгийг дагнан барьж бусдаас салган туйлшруулах нь нэгэн зүйлийн өрөөсгөл үзэл болж, харин тэр бүхний нэгдэл, шүтэн барилдсан тэнцвэрт харилцааг олж түшиглэх нь хоёр үгүйн аргагүй болох юм гэсэн утга санаа тодорхой гарч ирж байна. Дахин тэмдэглэхэд, энэ бол дундад номын хүрдэн – төв үзлийн гүн ухааны сэтгэлгээний үндсэн аргагүй гутгаар номын хүрдэн – сэтгэлийн төдийтнөө илрэн гарч залгамжлагдан баримтлагдаж байгаа хэрэг даруй мөн больюу гэж үзэж байна.

Гэхийн хамтаар, хоёр үгүйн үзлийн эл бүхий “ерөнхий” гэмээр утгын сацуу гутгаар номын хүрднээ түүний чухам тухайлсан өөр нэгэн утга басхүү байна гэж үзэж байна; энэ нь даруй бидний дээр цухас дурдсан утга буюу аливаа бүх эсрэг тэсрэгийн дотроос, тухайлж танин барихуй дахь онохуй, оногдохуй хоёрын нэгдэл, адилслыг онцлон товойлгож тавиад бүхнийг судлан авч үзэх үндсээ

⁷ Асанга, Их хөлгөний хураангуй, -Монгол Данжуур, 144 дүгээр боть, 28 дахь хуудас, дээд - доорд

болгож тулгуурласан тэрхүү утга мөн болно гэж үзэж байна: “Түүн дор хоёр үгүйн мөн чанар хэмээвээс барих хийгээд баримтлахуй ба өгүүлэгдэхүүн хийгээд өгүүлэхүй ба үүсгэхүй хийгээд үүсгэгдэхүүн ба үйлдэхүй хийгээд үйлдэгч дор тийн адхаглахаас хагацсан мөн болой”⁸ гэж энэхүү утгыг тодорхойлдог байна. Үүнд, сэтгэлийн төдийтний, ерөөс буддын гүн ухааны уламжлалт сэтгэхүйд, юмсын аль нэгэн тал, эгшнийг бусдаас нь салган, зогсонги болгож тогтоон барьж үзэх сэтгэхүйг тийн адхаг, тийн адхаглахуй хэмээн нэрийддэг нь тодорхой. Чингэхүйеэ, дээрх ишлэлээс үзэхүл, танин барихуй дахь онохуй, оногдохуй хоёрын шүтэн барилдлага дотоод адилслыг онож барьсан мэдлэгийг л “хоёр үгүйн үзэл” гэж нэрлэсэн нь илэрхий байна: энэхүү нэгдэл, шүтэн барилдлагыг мэдрэгдэн хүртэгдэгч ертөнцийн уг мөн чанар болгож үзсэн нь тодорхой харагдаж байна.

Энэ ч утга санаагаар Васубанду бээр онцолж тэмдэглэхдээ: “Номын чанарын бэлгэ чанар нь баригдахуун ба баригч хийгээд өгүүлэгдэхүүн ба өгүүлэн үйлдэгч ялгал үгүй түүнчлэнхүү чанар тэр нь номын чанарын бэлгэ чанар болой. Баригдахуун ба баригч ялгал үгүй алимад хийгээд өгүүлэгдэхүүн ба өгүүлэн үйлдэгч ялгал үгүй аль мөн тэр нь түүнчлэн чанар мөн бөгөөд тэр хэмээвээс номын чанарын бэлгэ чанар болой”⁹ гэсэн буй. Ингэж танин барихуй дахь онохуй, оногдохуй хоёрын ялгал үгүй гүн нэгдэл, адилсал нь чухамхүү хоёр үгүйн мөн чанар мөн гэж үзэхдээ тэрхүү хоёр үгүйг мэдрэгдэн хүртэгдэгч юмсын цаад уг мөн чанар буюу номын чанарын бэлгэ чанар болой хэмээх утгыг нэмэн тодосгосон болно. Онохуй, оногдохуйн гүн нэгдэл, адилслыг л түүнчлэн чанар мөн гэж, тэрхүү түүнчлэн чанар нь л номын чанарын бэлгэ чанар ч мөн болой хэмээн тодосгосон болно.

Чингэвээс, энд дурдагдан буй “номын чанарын бэлгэ чанар” хэмээх ойлголтыг арай дэлгэрүүлэн авч өгүүлъя. Үүнд, сэтгэлийн төдийтний гүн ухааны шасдир зохиолуудад, нэгэн талаас, мэдрэгдэн хүртэгдэгч юмс үзэгдлийн ертөнцийг тусган илэрхийлэгч болсон “ном” хэмээх ойлголт, нөгөө талаас түүний цаад мөн чанарыг нь тусган илэрхийлэгч “номын чанар” хэмээх ойлголт, ийм хоёр ойлголтыг давын өмнө ялгаж авч үздэг болно. Васубанду бээр “Ном ба номын чанарыг маш ялгагч тайлбар” хэмээх шасдиртаа: “Ялж төгс нөгчсөн бээр цогц ба язгуур хийгээд төрөн түгэхүй тэргүүтэн тийн агуулга алимадыг

⁸ Жнянашрибадра, Хутагт Ланка дор ажирсны тайлбар, -Монгол Данжуур, 130 дугаар боть, 11 дэх хуудас, доорд

⁹ Васубанду, Ном ба номын чанарыг маш ялгагч тайлбар, -Монгол Данжуур, 133 дугаар боть, 39 дэх хуудас, доорд - 40 дэх хуудас, дээд

номлосон, түүнийг товчлон хурааснаар энэ бүхэн нь хоёр бүлгээ. Юуны тул хэмээвээс, ном хийгээд номын чанараар хураасны тул болой. Цогц хийгээд язгуур ба төрөн түгэхүй тэргүүтэн тэр нь хурааваас хоёр зүйл буюу. Ийн ухагдахуй. Ном ба номын чанар болой”¹⁰ хэмээн цохож тэмдэглэсэн буй. Тийнхүү анхдугаар номын хүрднээ мэдрэхүйн бүх ертөнц чинь энэ шүү хэмээн үзүүлсэн таван цогц, арван хоёр төрөн түгэхүй хийгээд арван найман язгуур болон тэдгээрээс урган гарагч тийн агуулга алимад бүхэн нь энэхүү гутгаар номын хүрднээ ном ба номын чанар хэмээх хоёрхон ойлголтоор л зангилагдан хураагдах ажгуу гэсэн утга эл бүхий ишлэлээс тодорхой гарч ирж байна.

Ингэхдээ уг эх /Майдарын хутагтын/ шасдирт тэдгээрийг “бэлгэ чанараар маш ялгасугай”¹¹ гэж онцолж тэмдэглэсэн буй. Үүнийг тайлбарлан Васубанду өгүүлэхдээ: “тэдгээрийг бэлгэ чанарын үүднээс сайтар ялгах хэмээх нь орон ангидын үүднээс бус болой хэмээсний утга буюу. Өгүүлэрүүн, тэдгээрийг бэлгэ чанарын үүднээс маш ялгасугай хэмээхүй бээр хэр хурамхан ном хийгээд номын чанар тэдгээрийг сайтар ялгамуй за. Бусцар нь бус буюу”¹² гэж тэмдэглэсэн буй. Тийнхүү, эндээс үзэхүл, ном хийгээд номын чанар хэмээх орон зайд ангид тусдаа хоёр зүйл байгаа нь бус аа; мэдрэхүйн ертөнцийг энэ нэгэн хэсэг нь ном болой гэж, энэ нэгэн хэсэг нь номын чанар болой гэж, хоёр тусгаар хэсэгт эрс зааглан ялгалж байгаа хэрэг бус аа; харин ч ном хийгээд номын чанар хоёр нь орон зайд бол нэг л нэгдмэл юм байгаа юм, гагцхүү аливаа юм, үзэгдэл нэг бүр дээр түүний үзэгдэх байдал хийгээд мөн чанар хоёрыг зөвхөн бэлгэ чанарын нь үүднээс л ялган авч үзсэн хэрэг болох юм. Эл бүхий утгаар нь гутгаар номын хүрдэн – сэтгэлийн төдийтний гүн ухаан дахь “ном” хийгээд “номын чанар” хэмээх ойлголтуудыг өрнөдахины гүн ухааны сэтгэхүй дэх үзэгдэл хийгээд мөн чанар хэмээх хос ойлголтууд лугаа жишин авч үзэж болом ажгуу.

Чингэхүйеэ, угтаа “ном” гэж юу вэ?, “номын чанар” гэж юу вэ? Дээрхи шасдирт ном хэмээх ойлголтын агуулгыг хураангуйлан тодорхойлохдоо: “Номоор сайтар ялгасан нь орчлон болой. Түүний үйл нь хотлоос нисванисын бэлгэ чанарт мөний тул түүний мөн чанарт орчлонг номоор сайтар ялгалсан

¹⁰ Васубанду, Ном ба номын чанарыг маш ялгагч тайлбар, -Монгол Данжуур, 133 дугаар боть,, 38 дахь хуудас, доорд – 39 дэх хуудас, дээд

¹¹ Майтреянатха, Ном хийгээд номын чанарыг сайтар ялгагч, -Монгол Данжуур, 132 дугаар боть, 65 дахь тал, доорд

¹² Васубанду, Ном ба номын чанарыг маш ялгагч тайлбар, -Монгол Данжуур, 133 дугаар боть, 38 дахь хуудас, доорд.

хэмээн өгүүлвэй”¹³ гэж тэмдэглэсэн буй. Эндээс үзэхүл, сансар (samskara, төвд. gkor-bo) буюу мэдрэгдэн хүртэгдэгч юмс, үзэгдлийг нийтэд нь ном хэмээн нэрлэсэн болох нь тодорхой харагдаж байна. Үнэнхээр бүтчихсэн, өнө мөнхийн мэт сүндэрлэн үзэгдэгч мэдрэхүйн ертөнц нь би хийгээд минийхийлэн баримтлагч аливаа адхаг үзэл, шунал хүслийг хэзээд төрүүлж байдаг гэж үзээд, энэ утгаар нь түүнийг нисванисын бэлгэ чанарт хэмээн тодорхойлсон байна.

Тийнхүү “ном” хэмээх нь даруй үзэгдлийн ертөнц нь мөн, мэдрэгдэн хүртэгдэгч юмсын ертөнц нь мөн болно.

Үүний эсрэгээр, нөгөө “номын чанар” хэмээх ойлголтын нь тухайд бол түүнийг “номын чанараар сайтар ялгалсан нь гурван хөлгөний нирван болой. Нирваныг гурван хөлгөнөөр олон үйлдэх мөний тул гурван хөлгөний нирван хэмээн өгүүлэх болой. Эс бөгөөс гурван хөлгөн ч мөн бөгөөд гаслангаас нөгчсөн ч мөний тул гурван хөлгөний нирван хэмээх болой. Түүн дор номын чанар нь орон огоот болсны бэлгэ чанарт мөний тулд түүгээр хураасан нирван нь номын чанараар сайтар ялгалсан хэмээх өгүүлмүй”¹⁴ гэж тодорхойлдог. Тийнхүү хуурмаг үзэгдлийн ертөнцийг нь ном хэмээн нэрийдсэн ахул, түүний эсрэгээр орон огоот болсны бэлгэ чанар буюу үнэнхээр бүтсэн мөн чанарыг нь номын чанар хэмээн томъёолсон болох нь харагдаж байна. Гурван хөлгөн буюу ширвакийн хөлгөн, брадигабодын хөлгөн хийгээд бодисадын хөлгөн хэмээх гурван зам мөрийн аль нэгнээр замнан орон огоот болсон бэлгэ чанар буюу чухамхүү үнэнхээр бүтсэн уг чанарыг нь, орчлонгийн цаад уг язгуурыг нь онон барьсан, түүгээрээ би хийгээд минийхийлэн баримтлахын гачаалаас ангижирсан буюу, өөрөөр хэлэхүл, гаслангаас нөгчсөн нирваныг номын чанар хэмээн тодорхойлсон болно. Орчлон ертөнцийн уг язгуур чанарыг нь танин барьж, түүнд сэтгэлээрээ уусаж нэгдсэн нь, үлэмж амарлингуйд хүрсэн нь номын чанар болно гэж үзсэн нь тодорхой болж байна: “Орчлон ба нирван нугуудыг тэр мэт ном ба номын чанараар маш ялгалсан мөн буй заа”¹⁵ гэж дүгнэн тэмдэглэсэн буй.

Чингэхүйеэ, тэрхүү номын чанарт нь хэрхэн хүрэх вэ? өөрөөр хэлэхүл, тэрхүү “номын чанарын бэлгэ чанар” нь юу вэ? Энэ нь эргээд “номын бэлгэ чанар” хэмээх ойлголт лугаа мөнхүү авцалдан уялдах учиртай нь илэрхий. Энэ тухайд тус тайлбартаа Васубанду нотлон өгүүлэхдээ: “Бэлгэ чанарыг эс

¹³ Васубанду, Ном ба номын чанарыг маш ялгагч тайлбар, -Монгол Данжуур, 133 дугаар боть, 39 дэх хуудас, дээд.

¹⁴ Мөн тэнд.

¹⁵ Мөн тэнд.

өгүүлсний тул түүнийг үл мэдэх болой хэмээвээс, түүгээр бөгөөс түүний бэлгэ чанарыг өгүүлэхийн тулд номлосон: хоёр хийгээд ямар мэт илт өгүүлэл үзэгдсэн нь үнэнхээр бус хотол адхаг буюу. Номын бэлгэ чанар болой. Түүнээ баригдах хийгээд баригч бод, нүд хийгээд дүрс тэргүүтэн хоёр дор үзэгдэх алимад хийгээд түүн дор шүтсэн ямар мэт илт өгүүлэл алин мөн бөгөөд мөн чанар хийгээд ялгамжаалан нэрийдэхийн шүтээний мөн чанар тэр нь үнэнхээр бус хотол дор адхаглах болой. Тэр нь номын бэлгэ чанар болой”¹⁶ гэж тодорхойлсон буй. Энэдээс үзэхүл, нүд хийгээд дүрс тэргүүтэн танин барихуйн онохуй, оногдохуй хоёрыг аль алийг нь тус тусдаа, биеэ даагаад, үнэнхээр бүтчихсэн юм шигээр үзэж хандаж хэвшсэн манай төрөлх адхаг буюу хоёрт баримтлах манай хамт төрсөн авъяас л номын бэлгэ чанар нь мөн гэсэн утга тодорхой гарч ирж байна.

Алимад эсрэг тэсрэг агуулгыг, үүнд мөн танин барихуй дахь онохуй, оногдохуй хоёрыг хоёрт, тусгаарт баримтлагч төрөлх авъяас буюу юмсыг үнэнхээр бүтчихсэнд барьж хэвшсэн манай төрөлхийн сэтгэл ухамсар л онохуй, оногдохуй хоёрыг тус тусад нь тавьж, сөргөцөлдүүлэн үзэх, улмаар түүнд шүтсэн илт өгүүлэл буюу томъёолон нэрийдэхүй ёсон төдий бөгөөд манай төрөлх хотол адхагийн бүтээл мөн гэж, энэ утгаар нь адхагийн бүтээгдэхүүн төдий гэж, тэрхүү адхаг сэтгэл оюуныг **номын бэлгэ чанар** нь мөн гэж дүгнэсэн болох нь илт харагдаж байна.

Үнэндээ ч, мэдрэгдэн хүртэгдэгч бүх ертөнц угтаа үргэлжлэхийн хамт л тасалдаж, тасалдахын хамт л үргэлжлэх чанартай бус уу. Гагцхүү бидний өдөр дутмын жир амьдралд тэрхүү тасалданги чанарыг нь үргэлжид орхигдуулан гагц байхуй, оршихуй, үргэлжлэхүй чанарыг нь товойлгон авч тулгуурладаг шинжтэй бус уу. Чухамхүү эл утгаар нь, өнө мөнхөд бүтчихсэн мэтэд үзэгдэгч тэрхүү мэдрэхүйн ертөнцийг нь манай хотол адхаг буюу эндүү оюун сэтгэлийн бүтээл мөн гэж дүгнэж байгаа хэрэг болно. Харин тэрхүү үзэгдэх байдлаас нь даван гарч, цаад уг язгуурыг нь, язгуур чанарыг нь онон барихын тулд давын өмнө “дөрвөн ханандаа баригдагч” энэхүү төрөлх сэтгэлгээнийхээ хүлээснээс ангижирч, “модны цаад ойг” нь олон харж сурах учиртай бус уу. Үүнийг л гносеологийн үүднээс үндэслэн тавьж байгаад сэтгэлийн төдийтний гүн ухааны эл бүхий язгуур баримтлалын үндсэн утга учир орших юм гэж үзэж байна.

¹⁶ Васубанду, Ном ба номын чанарыг маш ялгагч тайлбар, -Монгол Данжуур, 133 дугаар боть, 39 дэх хуудас, доорд.

Тийнхүү алимад номын бэлгэ чанар нь манай үнэнхээр бус хотол адхаг буюу юмсыг үнэнхээр бүтчихсэнд баримтлагч манай хамт төрсөн авъяас, ташаа мэдэл сэтгэл болно. Харин тэрхүү мэдлийг ташаа хэмээн мэдсэн нь, үнэнд баримтлагч адхагаа давж чадсан нь дэруй “номын чанарын бэлгэ чанар” нь болох юм: “Мөнхүү ялгал үгүй нь зэрэг ямар мэт хоёр үгүйн тулд хийгээд өгүүлшгүйн тул бөгөөд ... тэр хэмээвээс ялгал үгүй түүнчлэн чанар болой. Тэр ч номын чанарын бэлгэ чанар болой хэмээснээр номын чанарын бэлгэ чанарыг датар буруу бус, хоцрол үгүйеэ үзүүлсэн болой”¹⁷ гэж үүнийг илэрхийлнэ.

Ингэж, “номын бэлгэ чанар” болсон “хоёр хийгээд илт өгүүлэлийн” эсрэгээр, өөрөөр хэлэхүл мэдрэхүйн юмсын үнэнхээр бүтчихсэн мэт үзэгдэх байдал хийгэд тэрхүү үзэгдэгч байдалд тулгуурласан томъёолон нэрийдэхүйн ёсны эсрэгээр тэдгээрийг үнэнхээр бүтээгүй, үнэнхээр бус хэмээн оносон “хоёр үгүй хийгээд өгүүлшгүй” чанар нь **номын чанарын бэлгэ чанар** нь болох юм; хоёрын үзлийн эсрэгээр танин барихуй дахь онохуй, оногдохуй хоёрын гүн нэгдэл, адилслыг танин барьсан “хоёр үгүй түүнчлэнхүү чанар” нь номын чанарын буюу нирваны бэлгэ чанар нь болох юм.

Мэдрэгдэн хүртэгдэгч бүхнийг хувиран өөрчлөгдөшгүй, өнө мөнхөд бүтчихсэн мэтэд үзэж заншсан төрөлх адхаг, авъяасны хүлээснээс ангижруулахад л, “модны цаад ойг” нь олж харж сургахад л буддын гүн ухааны бүх чиглэл, урсгалын нэгэн адилаар сэтгэлийн төдийтний гүн ухааны ч үндсэн утга учир агуулга орших юм. Энэ хүлээснээс ангижирсан нь л нирван болох юм. Төрөлх адхаг сэтгэлийг л үнэнхээр бус гэж оносон нь нирван болох юм. Үүгээрээ сансар, нирван хоёр буюу ном, номын чанар хоёр ч угтаа нэг л зүйл болох юм; нэг л зүйл дээр хураагдан нэгтгэгдэх ажгуу. “Хутагт Ланка дор ажирсны тайлбар” хэмээх шасдирт энэ ч үүднээс нотлон өгүүлэхдээ: “Гаслангаас нөгчсөний хязгаараа бээр алимад, орчлонгийн хязгаараа бээр алимад, тэр үе хоёрын завсар өчүүхэн нэгэн маш нарийн бээр буй бус. Билгээр шинжээд үзэвч үл үзэх буюу”¹⁸ гэж энэ тухайд онцолж тэмдэглэсэн буй. Тийнхүү сансар, нирван хоёр буюу, бүр өргөн утгаараа бол хийсвэр, тодорхой хоёр, янагуухуй чинагуухуй хоёрыг зөвхөн билиг оюунаар л ялган зааглаж үздэгээс бус, хэрэг дээрээ бол зөвхөн тэр бүхний шүтэн барилдсан дундын шилжимтгий харилцаа л бодитой байдаг юм гэсэн утга болно.

¹⁷ Васубанду, Ном ба номын чанарыг маш ялгагч тайлбар, -Монгол Данжуур, 133 дугаар боть, 40 дэх хуудас, дээд

¹⁸ Жнянашрибадра, Хутагт Ланка дор ажирсны тайлбар, -Монгол Данжуур, 130 дугаар боть, 25 дахь хуудас, дээд

Тийнхүү сэтгэлийн төдийтний гүн ухаанд, түүний язгуур үндэс болсон “хоёр үгүйн” аргагүйн үүднээс сансар, нирван хоёрыг, ерөөс үнэмлэхүй, харьцангуй хоёрыг ямагт шүтэлцүүлэн үзэж тодорхойлдог болно. Энэхүү харилцааг тодорхойлон “Хутагт тааллыг магад тайлахуй нэрт их хөлгөн сударт” өгүүлэхдээ: “Хамаг дор нэгэн чанарт бэлгэ чанар аль бүхүй тэр нь үнэмлэхүй хэмээх болой”¹⁹ хэмээн тодорхойлоод “Зарим нь хуран үүдэхүй бэлгэ чанар хийгээд үнэмлэхүй бэлгэ чанар тус бүр хэмээюү. Заримууд нь хуран үүдэхүй бэлгэ чанар хийгээд үнэмлэхүй бэлгэ чанар тус бүр болсон бус буй заа, хуран үүдэхүй бэлгэ чанар хийгээд үнэмлэхүй бэлгэ чанар тус бүр бус буюу хэмээмүй. Эдгээр язгууртны хөвгүүд нь энэ мэт хамаг үнэмлэхүй нь хуран үүдэхүй бүхэн лүгээ тус бүр хийгээд тус бүр бусаас үнэнхээр давсны бэлгэ чанар нарийн бөгөөд ямагт үл мэдэхүй. Буруу ёсон дор ямагт орсон мөн буюу”²⁰ гэж дүгнэсэн буй. Тийнхүү буддын дотоод тогтсон таалалд ч хуран үүдсэн буюу нэгж тодорхой хийгээд хуран эс үүдсэн буюу үнэмлэхүй хоёрыг тус бүр гэж үзэх, тус бүр бус, нэг нэгдмэл гэж үзэх хоёр үзэл баримтлал гарч ирсний аль алийг нь сэтгэлийн төдийтний гүн ухаанд буруу ёсон гэж шүүмжлээд угтаа эл харилцаа нь тус бүр гэх хийгээд тус бүр бус гэхийн аль алинаас үнэнхээр давсан, бэлгэ чанар нарийн гэж дүгнэж байна. Үүнд ч бидний авч үзэн буй “хоёр үгүйн” аргагүйн нэгэн гол баримтлал оршмуй.

Үүн лүгээ уялдуулан тэмдэглэхүйеэ, өмнөх номын хүрдэн – төв үзлийн гүн ухаанд сансар, нирван хоёрын салшгүй нэгдэл, шүтэн барилдлагын үзэл санааг мөнхүү онцлон тэмдэглэх бүлгээ: сансар хийгээд нирван хэмээх хоёр өөр ертөнц байгаа нь бус хэмээн сансарыг, сансарын уг язгуурыг танин барьсан нь л нирван мөн гэж сургана. Төв үзлийн гүн ухааныг үндэслэгч Нагаржуна бээр энэ тухайд нотлон өгүүлэхдээ:

“Сансар, нирван
Энэ хоёр буй бус,
Сансарыг огоот мэдснийг
Нирван хэмээн өгүүлмүй”²¹ гэж шүлэглэсэн буй.

Гэхийн хамтаар энэхүү думдад номын хүрднээ:

“Буй бээр тийн үл тонильюу.
Үгүй бээр энэ сансараас бус

¹⁹ Хутагт тааллыг магад тайлахуй нэрт их хөлгөн судар, -Монгол Ганжуур, 64 дүгээр боть, 13 дахь хуудас, доорд

²⁰ мөн тэнд, 8 дахь хуудас дээрд – доорд.

3. Буддын онолын шастарууд, УБ., 1999, 79 дэх тал

Бод хийгээд бод үгүйг огоот мэдснээр...

Тэр ямагт чанарыг үзэгсэд

Ертөнц ба нирваныг эрэмшин сэтгэхүй үгүй”²²

хэмээн юмсыг дан ганц буй гэхүл хувирч өөрчлөгдөшгүй мэт болоод нирваныг олохгүй, дан ганц үгүй гэхүл энэ сансар лугаа нийцэхгүй тул бод хийгээд бод бус тэргүүтэн алимад эсрэг тэсрэг бүхний “шүтээд барилдаж болсныг”²³ огоот мэдсэн нь л сансарыг уг язгуураар нь онон барьж буй хэрэг мөн, энэ нь л нирван мөн гэж сургана.

Тэгвэл сэтгэлийн төдийтний гүн ухаанд сэтгэлгээний энэ л аргагүйг уламжлан дэмжиж баримтлахдаа сансарын тэрхүү уг чанар, язгуурыг нь чухамхүү онохуй, оногдохуй хоёрын гүн адилсал, шүтэн барилдлага мөн хэмээн өөрийнхөөрөө тодосгон нарийвчилж байна, үүнд ч сэтгэлийн төдийтний гүн ухааны хоёр үгүйн аргагүйн гол онцлог, шинэлэг тал орших юм гэж үзнэ.

УЧЕНИЕ “ADVAYA-VADA” В ФИЛОСОФИИ

ВИДЖНЯНАВАДИНОВ

(РЕЗЮМЕ)

Г. ЛХАГВАСҮРЭН

В статье проанализирована адваявадческая концепция или учение о недвойственности в буддийской философии виджнянавадинов, которая, как считает автор, представляет собой основную методологическую установку данного направления философии буддизма. Показано, что учение о недвойственности по сути означает взаимообусловленность и взаимозависимость объекта и субъекта в процессе познания.

²² Буддын онолын шастарууд, УБ., 1999, 78 дахь тал

²³ Мөн тэнд.